*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд бараа материал худалдан авсан 4,112.6 сая, хандив 128.8 сая, балансаас балансд шилжүүлэн авсан 631.8 сая, нийт 4,873.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 4,348.9 сая, шилжүүлсэн 292.8 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 5,675.9 сая, нийт 10,317.6 сая төгрөгийг хассан байна.

Бараа материалын үлдэгдлийн бууралтад гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих болон бүтцийн өөрчлөлтөөр улсын төсвийн ерөнхийлөн захирагчид шилжсэн байгууллагуудын 5,675.9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг шилжүүлсэн нь нөлөөлжээ.

### 3.5.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 416.6 сая төгрөг болж, өмнөх оноос 64.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Нөөцийн барааны үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барааны нөөц | 30.5 | 62.7 | 32.2 |
| Үрийн нөөц | 109.7 | 109.7 | - |
| Тэжээлийн нөөц | 108.6 | 136.2 | 27.6 |
| Бусад нөөц | 103.4 | 107.9 | 4.5 |
| **Дүн** | **352.2** | **416.6** | **64.4** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нөөцийн бараа материал дансны үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

### 3.5.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 5,543.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,999.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 41.1 | 41.1 | - |
| БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 3,503.3 | 5,502.8 | 1,999.5 |
| **Дүн** | **3,544.4** | **5,543.8** | **1,999.5** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэлд аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамнан хэрэгжиж байгаа, хүлээж аваагүй хөрөнгийг хуримтлуулж бүртгэсэнтэй холбоотой. Мөн Тариалан эрхлэлтийг дэмжих санд 682.9 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, "Алтай орон сууцны корпорац" ААТҮГ-ын дансанд 230.0 сая төгрөгийн борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө бүртгэлтэй байна.

### 3.5.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 70,236.7 сая төгрөг болж, өмнөх оноос 90,887.6 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **154,962.9** | **62,193.4** | **(92,769.6)** |
| Барилга, байгууламж, орон сууц | 121,272.6 | 38,908.4 | (82,364.2) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 3,007.3 | 2,522.3 | (485.0) |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 9,941.0 | 3,894.2 | (6,046.7) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 3,703.0 | 655.7 | (3,047.3) |
| Зам, гүүрийн байгууламж | 8,686.9 | 7,855.4 | (831.6) |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1,412.5 | 298.4 | (1,114.2) |
| Бусад үндсэн хөрөнгө | 6,018.4 | 7,990.6 | 1,972.2 |
| Дуусаагүй барилга, байгууламж | 200.0 | - | (200.0) |
| Ном | 721.2 | 68.3 | (652.8) |
| **Биет бус хөрөнгө** | **6,161.3** | **8,043.3** | **1,882.0** |
| Программ хангамж | 58.8 | 108.2 | 49.4 |
| Бусад биет бус хөрөнгө | 6,102.6 | 7,935.2 | 1,832.6 |
| **Дүн** | **161,124.3** | **70,236.7** | **(90,887.6)** |

Тайлант онд үндсэн хөрөнгө өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 560.2 сая, хандиваар хүлээн авсан 3,485.6 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 2,580.6 сая, бусад эх үүсвэрээр 10,591.7 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн авсан 5.7 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 1,085.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, худалдсан 1,387.8 сая, акталсан 960.9 сая, балансаас баланст шилжүүлсэн 3,216.0 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 122,970.6 сая, бусад 1,463.9 сая, дахин үнэлгээний хорогдол 819.8 сая төгрөгийг хассан байна.

### 3.5.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 13,541.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,925.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Богино хугацаат өр төлбөр** | **4,054.2** | **2,557.2** | **(1,497.1)** |
| Богино хугацаат зээлийн өглөг | 31.7 | - | (31.7) |
| Өглөг | 1,636.5 | 1,322.2 | (314.4) |
| Урьдчилж орсон орлого | 2,385.9 | 1,235.0 | (1,151.0) |
| **Урт хугацаат өр төлбөр** | **11,412.2** | **10,984.1** | **(428.1)** |
| Урт хугацаат зээл | 11,412.2 | 10,984.1 | (428.1) |
| **Дүн** | **15,466.5** | **13,541.2** | **(1,925.2)** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өр төлбөрийн үлдэгдлийн бууралтад гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих болон бүтцийн өөрчлөлтөөр улсын төсвийн ерөнхийлөн захирагчид шилжсэн байгууллагуудын өр төлбөрийг шилжүүлсэн нь голчлон нөлөөлжээ.

Урт хугацаат өр төлбөр 10,984.1 сая төгрөг болж өмнөх оноос 428.1 сая төгрөгөөр буурсан.

Хөгжлийн банкнаас орон сууцны ашигтай талбайн хэмжээг 1м2-ийг 1.36 сая төгрөгөөр тооцсон боловч иргэдэд 1.4 сая төгрөгөөр борлуулснаар талбайн үнийн зөрүү 204.7 сая төгрөгийн орлогыг "Алтай орон сууцны корпорац" ААТҮГ урьдчилж орсноор тайлагнажээ.

Урт хугацаат зээлийн үлдэгдэлд дараах өр төлбөрүүд байна. Тухайлбал:

- "Алтай орон сууцны корпорац" ААТҮГ нь орон сууц, зогсоолын үнэ болох 7,830.6 сая төгрөгийг Хөгжлийн банканд төлөхөөр урт хугацаат өглөгийг 2019 онд тайлагнасан. Үүнээс 2020 онд 1,150.0 сая төгрөгийг, 2022 онд 180.9 сая төгрөгийг төлж 6,499.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант хугацааны эцэст зээлийн хүү 198.0 сая төгрөг, хуримтлагдсан хүү 18.2 сая төгрөг, алдангийн 28.5 сая төгрөгийн, нийт 6,744.4 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.
- Сангийн яам, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр "Ундарга-Алтай" ААТҮГ-т олгосон МОН-2301 төслийн 4,202.5 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл бүртгэлтэй.
- "Солонго дулааны станц" ААТҮГ нь аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас авсан 150.0 сая төгрөгийн зээлээс үндсэн зээл, хүү төлөөгүй тайлант оны эцэст 37.2 сая төгрөг болсон байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 89,909.0 сая төгрөг болж, өмнөх оноос 99,152.3 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 57,060.4 | 17,764.8 | (39,295.6) |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 16,661.8 | 16,797.6 | 135.8 |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 53.7 | - | (53.7) |
| **Хуримтлагдсан үр дүн** | **115,285.5** | **55,346.6** | **(59,938.9)** |
| Өмнөх үеийн үр дүн | 69,259.4 | 143,970.7 | 74,711.3 |
| Тайлант үеийн үр дүн | 5,827.6 | (96,049.2) | (101,876.7) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 40,198.5 | 7,425.0 | (32,773.4) |
| **Дүн** | **189,061.3** | **89,909.0** | **(99,152.3)** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

УСНББОУС-3 дагуу гүйцэтгэл, үр дүнгээр санхүүждэг, бүтцийн өөрчлөлтөөр шилжсэн байгууллагуудын авлага, өглөг, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хаасан байна.
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 32,773.4 сая төгрөгөөр буурсан нь үлдэх өртөггүй, хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг данснаас хассантай холбоотой.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн 2022 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 19,091.3 сая төгрөг, татварын болон татварын бус орлогоос 2,735.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 10,967.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 3,578.1 сая төгрөг, аймгийн төсвийн урьд оны үлдэгдлээс 830.0 сая төгрөг, тусгай сангийн үлдэгдлээс 200.0 сая төгрөг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн эргэн төлөлтөөс 358.0 сая төгрөг, орон нутгийн сангаас 1,000.0 сая төгрөгийг тус тус бүрдүүлж нийт зарлагыг 38,760.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьсан байна.

Аймгийн 2022 оны төсвийг төсвийн төслийн саналд тусгасан дүнгээр буюу нийт зардлыг 38,760.1 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн зардлыг 3 удаагийн тодотголоор 3,653.9 сая төгрөгөөр бууруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 18 хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 15,103.7 сая, татварын болон татварын бус орлогоос 3,595.7 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 10,142.7 сая, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 3,898.1 сая, аймгийн төсвийн урьд оны үлдэгдлээс 1,808.0 сая, тусгай сангийн үлдэгдэл 200.0 сая төгрөг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн эргэн төлөлтөөс 358.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 15,103.7 сая төгрөг, татварын болон татварын бус орлогоос 40,971.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 9,875.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,315.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 196.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 44,508.1 сая төгрөг буюу 86.3 хувьтай байгаа нь урсгал зардлыг 3,071.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 3,144.5 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийг 868.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 1* Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70105-Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа | 3,009.5 | 2,617.6 | 391.9 | 87.0 |
| 2 | 70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 16,374.6 | 15,406.8 | 967.8 | 94.1 |
| 3 | 70417-Мэргэжлийн хяналт | 124.2 | 122.6 | 1.6 | 98.7 |
| 4 | 70426-Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх | 252.7 | 222.9 | 29.8 | 88.2 |
| 5 | 70503-Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт | 17,567.5 | 14,590.9 | 2,976.6 | 83.1 |
| 6 | 70801-Мал аж ахуйг хөгжүүлэх | 150.0 | - | 150.0 | 0.0 |
| 7 | 70802-Газар тариалан хөгжүүлэх | 50.0 | 10.0 | 40.0 | 20.0 |
| 8 | 71403-Ойжуулалт | 98.2 | 97.1 | 1.1 | 98.9 |
| 9 | 71411-Хүрээлэн буй орчны бодлого | 668.7 | 638.8 | 29.9 | 95.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | удирдлага | | | | |
| 10 | 71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 460.0 | 429.0 | 31.0 | 93.3 |
| 11 | 71701-Биеийн тамир спорт | 369.6 | 366.2 | 3.4 | 99.1 |
| 12 | 71702-Соёл урлаг | 1,387.5 | 1,364.2 | 23.3 | 98.3 |
| 13 | 71801-Сургуулийн өмнөх боловсрол | 1,795.7 | 1,728.2 | 67.5 | 96.2 |
| 14 | 71802-Ерөнхий боловсрол | 5,090.9 | 4,930.7 | 160.2 | 96.9 |
| 15 | 71804-Мэргэжлийн боловсрол | 596.4 | 594.9 | 1.5 | 99.7 |
| 16 | 71806-Насан туршийн болон албан бус боловсрол | 26.8 | 19.4 | 7.4 | 72.4 |
| 17 | 71902-Нийгмийн халамж | 130.0 | 93.2 | 36.8 | 71.7 |
| 18 | 72101-Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | 3,440.0 | 1,275.6 | 2,164.4 | 37.1 |
| | **Нийт зардлын дүн** | **51,592.3** | **44,508.1** | **7,084.2** | **86.3** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### *3.5.3 Нэмэлт төсөв*

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансны эхний үлдэгдэл 95.1 сая төгрөг, тайлант онд 2,477.6 сая төгрөгийн санхүүжилт орж, 2,572.7 сая төгрөгийн зардал гаргажээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэвэлмаа, аудитор С.Санчирмаа, Н.Гэрэлмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/550 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 174,386.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,615.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дараах арга хэмжээ авсан байна.

Аймгийн Засаг даргын "Төсвийн ил тод байдлыг хангаж, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх тухай" 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэхээр баталсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.1[1], Засгийн газрын 204 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/576 дугаартай "Орон нутгийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг хүлээлгэн өгөх ажлын хэсэг байгуулах тухай" захирамж гарсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 59 дүгээр тушаалаар орон нутгийн өмчит байгууллагуудын 25 автотээврийн хэрэгслийг худалдан борлуулахаар шийдвэр гарсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг үзэхэд дараах нийтлэг зөрчил илэрсэн. Үүнд:

- Засаг даргын зөвлөх, орлогчийн орон тоонд илүү ажиллуулж 18.2 сая төгрөгийн цалин олгосон
- Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчдад дэмжлэгийг тэтгэмжтэй давхардуулан 2.4 сая төгрөгийг олгосон.
- Төрийн хэмнэлтийн горим зөрчиж хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр 472.5 сая төгрөгийн шагнал урамшуулал олгосон.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн горим зөрчиж 160.9 сая төгрөгийг шагнал урамшуулал, бэлэг дурсгалын зүйлст зарцуулсан
- Иргэдэд 293.1 сая төгрөгийн дэмжлэг олгосон
- Төрийн хэмнэлтийн горим зөрчиж 3.3 сая төгрөгийн тээвэр, шатахуун зарцуулсан
- Нэгдсэн халаалтын системд холбосон боловч дулааны тоолуур ашиглаагүй
- Байгууллагын автотээврийн хэрэгсэл нь бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй.

**4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд эрх шилжин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 4,250.6 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 94.6 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг мэдээлээгүй байна. "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар тус зөрчилд шийдвэр өгсөн байна. Шилэн дансны цахим хуудсанд

[1] Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

төсөв өмч, хөрөнгө зарцуулах 201.9 сая төгрөгийн 30 захирамж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 23,973.1 сая төгрөгийн 60 ажлыг мэдээлээгүй.
Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Зөрчилгүй" санал дүгнэлт өгч, нийт 316.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж 237.8 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага, 6 зөвлөмжийг хүргүүлснээс 78.3 сая төгрөгийн зөрчил хууль хяналтын байгууллагад шалгагдаж, бусад зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| **Албан шаардлага** | 7 | 316.1 | 6 | 237.8 | 1 | 78.3 | 75% |
| **Зөвлөмж** | 6 | - | 2 | - | 2 | - | 67% |
| **Нийт дүн** | **13** | **316.1** | **12** | **237.8** | **1** | **78.3** | **71%** |

Өмнөх оны буюу 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 1,345.9 сая төгрөгийн 8 албан шаардлагаас 298.1 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, аудитын явцад 48.0 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, 999.8 сая төгрөгийн шийдвэрийг хэрэгжүүлэхээр арга хэмжээ авч ажиллаж байна.

### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар урт хугацаат өр төлбөрийн барагдуулалтыг үзэх нь зүйтэй. Учир нь Сангийн яам, Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газар хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр "Ундарга-Алтай" ААТҮГ -т 2015 онд 4,626.6 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд 2021 оныг хүртэл огт төлөлт хийгдээгүй байна.

Тус МОН-2301 төслийн урт хугацаат өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зээлдэгч, зээлдүүлэгч талын буруутай үйл ажиллагааны улмаас тайлант оны байдлаар хугацаа хэтэрсэн 2,444.1 сая төгрөг, тооцоолсон алданги 19,048.6 сая төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгээс суутган тооцохоор болсон нь цаашид орон нутгийн төсөвт хүндрэл учруулахаар байна.

Мөн үндсэн зээлээс 4.1 дахин өндөр буюу 19,048.6 сая төгрөгийн алдангийн тооцооллыг дахин нягталж үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 29 төсвийн байгууллага, 76 тусгай сан, 20 төрийн сан, 13 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нийт 138 санхүүгийн тайлан нэгтгэснээс 56 нэгж, байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 80 нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн үе шатны ажлыг хэсэгчлэн хийж биеэ даасан дүгнэлт гаргалгүйгээр түүвэрт хамруулсан. Аудитад хамрагдаагүй, санхүүгийн тайлан ирүүлээгүй 2 байгууллага байна. (Орон сууцны алба ОНӨААТҮГ, "Дарив-Эрчим хүч"ААТҮГ)

Аудитад хамруулсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" 24, "Хязгаарлалттай" 32 санал дүгнэлт өгсөн байна.

**Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:** ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад нийт 25,270.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 14,733.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1,230.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 10,519.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 19 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох тухай албан шаардлага, 33,415.9 сая төгрөгийн 56 зөвлөмжийг хүргүүлж, 16,812.0 мянган төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар МУЕА-т хүргүүлсэн.

**Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 1,301.4 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,301.4 сая төгрөгийн 7 заалт албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

**5.1 Албан шаардлага**

- Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 6 аж ахуй нэгжийн 1.8 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны дансанд байршуулаагүй нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12-т "Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина." Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т "ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д "харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх;" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Аймгийн аюулгүйн нөөцөд гамшгаас хамгаалах сангаас бэлтгэсэн 99.1 сая төгрөгийн өвс тэжээлийг борлуулсан, иргэдээс авах өвсний авлагыг 29.1 сая төгрөгөөр дутуу тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын ирүүлсэн судалгаа, баримтад үндэслэн тулган баталгаажуулалт хийхэд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй боловч байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө батлуулаагүй 107 аж ахуйн нэгж байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12-т "Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина." Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т "ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны дансанд нэгээс дээш жилийн насжилттай 172.3 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид барьцаа хөрөнгийг буцаан олгоогүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12-т "Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина." Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т "ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;", Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дугаар тушаалаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Сум, дүүргийн Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг тухайн сум, дүүргийн төрийн сангийн төлөөлөгч жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, 12 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ." 4.2-т "Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг санхүүгийн асуудал хариуцсан нэгж тухайн оны 12 дугаар сард багтаан гаргана." гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Орон нутгийн 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 1,041.8 сая төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 63 дугаар тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд нь удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр 56.4 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт,

шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.", Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шилэн дансны цахим хуудсанд төсөв өмч, хөрөнгө зарцуулах 201.9 сая төгрөгийн 30 захирамж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 23,973.1 сая төгрөгийн 60 ажлыг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Аймгийн Засаг даргын 2022 оны "Төсвийн ил тод байдлыг хангаж, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх тухай" 01 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн холбогдох арга хэмжээг давтан үнэлэхэд биелэлт 69 хувьтай, албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байгаа нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-т "Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг бодитой тооцох

2. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

*Илрүүлэлт:* Засаг даргын нөөц хөрөнгийг сум бүрд харилцан адилгүй баталж байна. Жишээ нь: Цогт сум нийт аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, татварын болон татварын бус орлогын 21 хувийг ЗДНХ-д хуваарилан зарцуулсан байна. Хүн амын тоо адил Жаргалан, Тайшир сумдын ЗДНХ-ийн төлөвлөлтийг үзэхэд Тайшир сум 3 дахин их

хөрөнгө хуваарилж зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, батлах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТЕЗ-ийн харьяа байгууллагууд | 177 | 14,733.9 | 36 | 2,717.7 | 141 | 12,016.2 | 177 | 14,733.9 | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Аймгийн ТЕЗ | 4 | 1,301.4 | - | - | 3 | 1,301.4 | 1 | - | - | - | - | - |
| ТЕЗ-ийн харьяа байгууллагууд | 496 | 8,798.1 | 268 | 7,526.3 | 17 | 23 | 19 | 16 | 1 | 17 | 496 | 8,798.1 |
| **Дүн** | **500** | **10,099.5** | **271** | **8,827.7** | **18** | **23** | **19** | **16** | **1** | **17** | **500** | **10,099.5** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | |
| Аймгийн ТЕЗ | 1 | - | - | - | 1 | - |
| ТЕЗ-ийн харьяа байгууллагууд | 24 | 568.4 | 17 | 568.4 | 7 | - |
| **Дүн** | **25** | **568.4** | **17** | **568.4** | **8** | **-** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | |
| ТЕЗ-ийн харьяа байгууллагууд | 67 | 1,172 | 37 | 1,161 | 30 | 11 |
| **Нийт дүн** | **92** | **1,740.2** | **54** | **1,729.7** | **38** | **10.5** |

| № | АГАДУТ | АГАДУТ-ын дэд анги | Алдаа зөрчлийн товч утга | Мөнгөн дүн (сая.төг) | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт | | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гарсан шийдэл | Байгууллагын санал тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гарсан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | | |
| 4 | Нийт өглөг ✓ | Богино хугацаат өглөг | Сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны дансанд нэгээс дээш жилийн насжилттай 172.3 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид ямар шалтгааны улмаас барьцаа хөрөнгийг буцаан олгоогүй нь тодорхойгүй байна. | 172.3 | 172.3 | 172.3 | УСНББОУС-1, АДБОУС 1250, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98 MNS-6817-4:2020 стандартын 5.3.1 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12-т "Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина." Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т "ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьялах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;", Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Сум, дүүргийн Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төлөвлөлт, зарцуулалтын жилийн тайланг тухайн сум, дүүргийн төрийн сангийн төлөөлөгч жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, 12 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ." 4.2-т "Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төлөвлөлт, зарцуулалтын жилийн тайланг санхүүгийн асуудал хариуцсан нэгж тухайн оны 12 дугаар сард багтаан гаргана." | Хуулийн хэрэгжилт | Албан шаардлага | Санал, тайлбар байхгүй | Санал, тайлбар байхгүй | Албан шаардлага |
